МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 30 өдөр Дугаар А/197 Чингис хот

Эд хөрөнгө актлах, шилжүүлэх тухай

1. Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.2, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.2.3, 77.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 18 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

2. Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын Тамгын газрын эзэмшилд бүртгэлтэй 18,800,000 төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй цаашид ашиглах боломжгүй болсон NISSAN DATSUN маркийн автомашиныг актлагсугай.

3. Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны эзэмшилд бүртгэлтэй 16,700,000 төгрөгийн балансын үнэтэй, 2,319,444 төгрөг 72 мөнгөний үлдэх өртөгтэй STAREX маркийн 4500ХЭҮ улсын дугаартай автомашиныг "Өндөрхаан хот тохижилт" орон нутгийн өмчит үйлчилгээний газарт шилжүүлсүгэй.

4. Эд хөрөнгийг актлах шилжүүлэх ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Л. Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ИДЭРБАТ

231011270